

**10-Р АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

Анги бүлэг ...
Хугацаа: 60 минут

Сурагчийн нэр

ХУВИЛБАР-А

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ

1 Хүн амын болон соёлын нөхөн үйлдвэрлэлээрээ өөрийн залгамж, тогтвортой чанарыг хангадаг, нэг нутаг дэвсгэр дээр амьдардаг, өөрийн зохион байгуулалт, эмх цэгц бүхий, улс төрийн хувьд биеэ даасан өөрсдийгөө тухайн нийгэмд харьяалуулдаг хүмүүсийн тогтвортой нэгдлийг юу гэдэг вэ?
а. Бүлэг б. Нийгэм в. Үндэстэн d. Гэр бүл e. Нийтлэг **1 оноо**

2 Аль нь олдмол статусын жишээ болох вэ?
а. Би айлын дунд хүү2
б. Миний ээж Боржигин овогтой
в. Иргэн Г.Сумъяа Завхан аймгийн уугуул
d. Сурагч Б.Эрхсаран РМ радиогийн хөтлөгчөөр ажилладаг.
e. Сурагч Б.Эрмүүн айлын дунд хүү бөгөөд өндөр нуруутай **1 оноо**

3 Нийгэмшилтийн явцад хувь хүн өөрийгөө нийгмийн тодорхой бүлэг, нийтлэг, нийгэмд харьяалуулан, тэрхүү бүлэг, нийтлэг, нийгмээ илэрхийлэгч онцлог шинжийг нь тээгч нь болдог. Үүнийг ямар ойтголтоор илэрхийлдэг вэ?
а. Нийгэмшилт Б. Адилсал в. Тээгч d. Нийгмийн нийтлэг e. Бүлэг **2 оноо**

4 Нийгэмшилтийн гол агентад аль нь хамаарахгүй вэ?
а. Гэр бүл в. Сургууль в. Үе тэнгийнхэн d. Хэвлэл мэдээлэл e. Сүм хийд **2 оноо**

5 “Соёл нь хүн нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг ёс суртахуун, хууль, зан заншил болон бусад чадвар, дадлуудыг багтаасан цогц бүхэл юм ” гэж дараах эрдэмтдээс хэн нь зсэн бэ?/2 оноо/
а. Р.Бенедикт в. Э.Тайлор в. Ж.Мёрдок d А.Гидденс e. Э.Кассирер **2 оноо**

6 Нийт хүн төрөлхтний хувьд хүлээн зөвшөөрөгддөг утгат чанарууд бөгөөд сайн үйл, эрх чөлөө, шударга ёсыг ямар ч ард түмэн эрхэмлэдэг. Энэ нь:/1 оноо/
а. Үнэлэмж в. Үнэлэмжийн баримжаа в. Үнэлгээ
d. Үнэт зүйл e. Тохирох хариулт алга **1 оноо**

7 Өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|-------|---|---|
| 1 | Домог | а | Өөрийн нэр томъёо, багаж хэрэгсэл, туршилтын тоноглол зэргийг ашигладаг.Энэ зорилгын дагуу эрдэм судалгааны байгууллагууд ажилладаг. |
| 2 | Шашин | ь | Хүн төрөлхтний язгуур сэтгэлгээ бөгөөд эртний нийгэмд хамаарна.Ёс жаяг, зан үйл хэвшиж тогтсоноор хорио цээрийн хэм хэмжээ, бэлгэдлийн эх |

| | | |
|---|---------------|--|
| | | үндэс тавигдсан. |
| 3 | Шинжлэх ухаан | с Энэ байгууллагын хамгийн том хэлбэр нь сүм хийд бөгөөд археологийн судалгаагаар сүсэг бишрэлийн энгийн хэлбэрүүдийг 40 мянган жил оршин тогтносон гэж судлаачид тэмдэглэдэг. |

- a. 1Б2с3а б. 1а2с3Б с. 1с2Б3а б. d.1с2а3Б e. 1Б2а3с

8

Соёлын түгээмэл шинжийн илрэх хүчин зүйсэд аль нь хамаарах вэ?

- A. Үндэстэн бүхэнд өөр өөрийн хэл, бэлгэдэл байдаг
 B. Бүх үндэстэнд нийтлэг үнэлэмж бий
 C. Үндэстэн бүрийн соёлд газар зүйн байрлал, уур амьсгал, эрхлэх аж ахуй зэрэг нь нөлөөлдөг
 d. Үндэстэн бүхэн өөр өөрийн зан үйл, сүсэг итгэл, ёс заншилтай
 e. Дээрх бүгд хамаарна.

2 оноо

9

Хүн бүр хаана, хэн болон төрж, хэрхэн амьдарч байгаагаас үл хамаарч хүмүүн болохынхоо хувьд адилхан үнэ цэнэтэй, эрх тэгш байх тухай ойлголтыг эрх зүйн шинжлэх ухаанд хэрхэн нэрлэдэг вэ?

- a. Хүний эрх б. Хүний эрхэм чанар с. Тэгш байдал
 d. Тэгш эрх e. Хүний үнэ цэн, нэр төр

1 оноо

10

“Хүний үндсэн эрх, хувь хүний нэр төрд итгэх итгэлийг дахин батлах...” гэсэн зорилготой НҮБ хэдэн онд байгуулагдсан бэ?

- a. 1924 он б. 1940 он с. 1945 он d. 1948 он e. 1992 он

1 оноо

11

Эрх зүйн бүрэн бус чадамжтай хүн гэж хэнийг хэлэх вэ?

- a. 14-18 хүртэлх насны хүүхэд б. 18- аас дээш насны хүмүүс
 с. 7-14 хүртэлх насны хүүхэд d. 7 хүртэлх насны хүүхэд
 e. 16 хүртэлх насны хүүхэд

2 оноо

12

Хариуцлага тооцох хэлбэрүүдийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|-----------------------------------|---|---|
| 1 | Төртэй хариуцлага тооцох | а | Төрийн бус байгууллага зэрэг нийгмийн бусад бүх хэсгүүд хүний эрхийг хамгаалах үүргийг хүлээнэ. |
| 2 | Хувь хүнтэй хариуцлага тооцох | б | Хүн бүр хүний эрхийг хүндэтгэх болон хүний эрхийг зөрчдөг байгууллага, хүмүүстэй тэмцэх үүрэгтэй. |
| 3 | Бусад этгээдтэй хариуцлага тооцох | с | Хүний эрхийг төр өөрийн үзэмжээр өгдөггүй бөгөөд хүндэтгэх, хамгаалах, хангахаас татгалзах ёсгүй |

- a. 1Б2с3а б. 1а2Б3с с. 1с2Б3а d.1а2с3Б e.1Б2а3с

4 оноо

13

Иргэн болон төр аж, ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүнийн асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн харилцааг.гэнэ

- a. Нийгмийн хамгааллын тогтолцоо б. Нийгмийн халамж

2 оноо

14

ДНБ-ийг тодорхойлохдоо илүүц зүйл дурдсан бол аль нь вэ?

- a. Эцсийн бараа үйлчилгээний зах зээлийн үнийн дүн
- b. Тухайн улсын хэмжээгээр буюу газар нутаг дээр үйлдвэрлэсэн байх
- c. Нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн байх
- d. Тухайн жилд үйлдвэрлэсэн боловч борлогдож амжаагүй бүтээгдэхүүний үнэ
- e. Эдийн засгийн салбар дах хууль бус үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг оруулж тооцохгүй байх

2 оноо

15

Тухайн улсын хэмжээнд жилийн турш үйлдвэрлэсэн баялгийг орлогын нийлбэр дүнгээр тодорхойлох аргыггэнэ.

- a. ДНБ-ийг орлогоор тооцох
- Б. ҮНБ-ийг зардлаар тооцох
- c. ДНБ-ийг зардлаар тооцох
- d. ҮНБ-ийг орлогоор тооцох
- e. Нэрлэсэн ДНБ-ийг орлогоор тооцох

1 оноо

16

Өгөгдлийг зөв харгалзуулна уу ?

- 1. Цэвэр экспорт
 - 2. Бодит ДНБ
 - 3. Нэрлэсэн ДНБ
 - 4. Нэг хүнд ногдох ДНБ
 - a. Экспортын орлогоос импортын зардлыг хасах
 - Б. ДНБ-ийг нийт хүн амд харьцуулсан үзүүлэлт
 - c. Өнөөгийн үнээр тооцсон ДНБ
 - d. Тогтмол үнээр тооцсон ДНБ
- a. 1d2Б 3c 4a Б. 1c2Б3d4a c. 1a 2Б 3c 4d d. 1Б 2c 3a 4d e. 1a 2d 3c 4Б

3 оноо

17

Ажилгүйдэл 1,0% өсөхөд үйлдвэрлэлийн хэмжээ 2, 5 % буурдаг болохыг Английн эрдэмтэн баталжээ. Энэхүү ажилгүйдэл ба ДНБ -ний хоорондох хамаарлыггэнэ

- a. Лафферын муруй
- Б. Оукены хууль
- c. Госсений хууль
- d. Лоренцийн муруй
- e. Ажилгүйдлийн түвшин

2 оноо

18

Гүйлгээнд байх мөнгөний тоо хэмжээ нийт бүтээгдэхүүн , үйлчилгээний үнэ буюу ДНБ-ний өсөлтийн хурдаас илүү хурдтай өсөх нь инфляцийн аль төрөлд хамаарах вэ?

- a. Эрэлтийн инфляци
- Б. Зардлын инфляци
- c. Гипер инфляци
- d .Мөлхөө инфляци
- e. Цогио инфляци

1 оноо

19

Олон түмэн өөрөө өөрийгөө удирдах хэлбэр бөгөөд Эртний Грект иргэн бүрийг төрийг удирдах хэрэгт оролцуулдаг ардчилсан төрийн хэлбэр анх үүссэн юм. Энд ардчиллын аль хэлбэрийн тухай өгүүлсэн байна вэ?

- a. Сонгодог ардчилал
- Б. Шууд ардчилал
- c. Элит ардчилал
- d. Төлөөллийн ардчилал
- e. Олон ургальч ардчилал

2 оноо

20

Одоо мөрдөгдөж байгаа Үндсэн хууль хэдэн бүлэг, хэдэн зүйлтэй вэ?

- a. 6 бүлэг 70 зүйлтэй
- Б. 8 бүлэг 49 зүйлтэй
- c. 4 бүлэг 69 зүйлтэй
- d. 7 бүлэг 60 зүйлтэй
- e. 12 бүлэг 282 зүйлтэй

2 оноо

21

1990 оны өмнөх Монгол төрийн үйл ажиллагаанд аль нь үл хамаарах вэ?

- a. Төвлөрсөн төлөвлөлтөөр нийгмээ хөгжүүлэх
- b. Улс хоршооллын өмчийг шүтэж амьдрах
- c. Хүний эрхийн түгээмэл зарчмуудыг ёс төдий тунхаглах
- d. Нэг намын үзэл суртлыг үнэний дээд болгон тунхаглах
- e. Улс түмний харилцан ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэх

2 оноо

22

Монгол улсын эрх мэдлийн хуваарилалтыг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|-------------------------|---|--|
| 1 | Хууль тогтоох эрх мэдэл | а | Улсы дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурор |
| 2 | Гүйцэтгэх эрх мэдэл | ь | Улсын Их Хурал |
| 3 | Шуух эрх мэдэл | с | Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар |

- a. 1a2b3c Б. 1b2c3a c. 1c2a3b d. 1c2b3a e. 1a2c3b

3 оноо

23

1992 оны Монгол улсын Үндсэн хуульд зааснаар иргэний журамт үүрэгт хамааралгүй нь аль вэ?

- a. Сурч боловсрох Б. Хөдөлмөрлөх c. Эрүүл мэндээ хамгаалах
- d. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх e. Байгаль орчноо хамгаалах

1 оноо

24

Фрийдом Хаус байгууллагын судалгаагаар 2016 онд Монгол улс хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн аль ангилалд багтсан бэ?

- a. Хагас чөлөөтэй улс Б. Чөлөөт буюу эрх чөлөөт улс
- c. Хагас чөлөөтэй буюу бүрэн бус улс
- d. Чөлөөт улс e. Авилгын төсөөллийн индекс багатай улс

2 оноо

25

Дэлхийн улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадаад бодлого, үйл ажиллагааг судалдаг нийгмийн шинжлэх ухааны салбарыг хэрхэн нэрлэдэг вэ?

- a. Дипломат харилцаа Б. Гадаад харилцаа
- c. Олон талт харилцаа d. Олон улсын харилцаа e. Дипломат бус харилцаа

2 оноо

26

Олон улсын харилцаанд улс орныг албан ёсны гэхдээ бүрэн бус хүлээн зөвшөөрснийг гэж нэрлэдэг.

- a. Статускво Б. Де-факто c. Автономит d. Де-юре e. Транзит

2 оноо

27

Мөнхийн дайсан гэж байхгүй, мөнхийн хөрш байдаг ” гэж хэн хэлсэн бэ?

- a. А.Линколин Б. М.Вебер c. К.Маркс d. У.Черчилль e. Ш.Монтескье

2 оноо

28

“Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллахдаа шат дарааллыг эрхэмлэсэн, Монгол улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн Монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэхэд чиглэсэн байна ” Энэ нь Монгол улсын гадаад бодлогын аль зарчим бэ?

- a. Тэнцвэртэй байх Б. Идэвхтэй байх c. Үндэсний эрх ашигт нийцсэн байх

2 оноо

d. Олон тулгуурт байх e. Шат дараалсан байх

29

Монгол Улсын хоёр хөрштэйгээ харилцах чиглэлд аль нь хамаарахгүй вэ?

- a. Эдийн засгийн болон улс төрийн чиглэл
- b. Соёлын болон боловсролын чиглэл
- c. Хүмүүнлэгийн болон шинжлэх ухааны чиглэл
- d. Хөршийн болон хамтын ажиллагааны чиглэл
- e. Дээрх бүгд хамаарна

2 оноо

30

Монгол улс хэдэн онд нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан бэ?

- a. 1990 b. 1992 c. 1994 d. 1996 e. 1998

2 оноо

ХОЁРДУГААР ХЭСЭГ

31

Нийгмийн институтуудыг чиг үүрэгтэй нь зөв харгалзуулаарай.

| | | | |
|---|-------------|---|--|
| 1 | Гэр бүл | a | Нийгмийн гишүүнийг төрүүлэх, нийгэмшүүлэх |
| 2 | Боловсрол | ь | Нийгмийн нэгдэл нягтралыг хангах, дээд ариун зүйлд итгэх, сүсэглэх |
| 3 | Эдийн засаг | с | Амгалан тайван байдлыг хангах, нийтлэг асуудлыг шийдэх |
| 4 | Төр засаг | d | Хэрэгцээт бараа, үйлчилгээгээр хангах |
| 5 | Шашин | e | Шинэ мэдлэг бүтээх, мэдлэгийг хойч үедээ уламжлуулах |

5 оноо

32

Үнэлэмжүүдийн өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|------------------------|---|----------------|
| 1 | Ёс суртахууны үнэлэмж | a | сайхан, муухай |
| 2 | Шашны үнэлэмж | ь | буян, нүгэл |
| 3 | Гоо сайхны үнэлэмж | с | сайн, муу |
| 4 | Шинжлэх ухааны үнэлэмж | d | үнэн, худал |

4 оноо

33

Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Монгол улсын Үндсэн хууль | a | Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэннэх хэмжээний төгрөгөөр торгоно. |
| 2 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль | ь | Эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн баялгаас тэнцүү хүртэх боломж, нөхцлийг хангах |
| 3 | Эрүүгийн хууль | с | Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. |
| 4 | Хүний эрхийн түгээмэл тунхаглал | a | Эрүүгийн харицлага нь хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төр, алдар хүндийг гутаах шинжгүй байна. |
| 5 | Зөрчлийн тухай хууль | e | Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх нь иргэний үндсэн үүрэг |

5 оноо

34

Өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|--|---|--|
| 1 | Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл | a | Ажилтан сахилгын зөрчлийг давтан гаргасан, эсвэл 60 нас хүрч тэтгэвэр авах эрх үүссэн бол |
| 2 | Гэрээ байгуулах үндэслэл | ь | Хуульд заасан талууд тохиролпсон нэг баримт үйлдэж. гарын үсэг зурах буюу саналыг зөвшөөрснөө илэрхийлэх |
| 3 | Хөдөлмөрийн гэрээ цуцлах үндэслэл | с | Оюуны үнэт зүйл бүгээх. үндэслэлгүйгээр эд юмс олж авах. эзэмших |

3 оноо

35

Утгаар нь зөв тохируулна уу?

| | | | |
|---|-----------------------|---|--------------------------------------|
| 1 | Шилжилтийн ажилгүйдэл | a | Эдийн засгийн уналтын үед бий болдог |
| 2 | Бүтцийн ажилгүйдэл | b | Цаг улирлын байдалтай холбоотой |
| 3 | Мөчлөгийн ажилгүйдэл | c | Шинэ салбар мэргэжлийн шаардлага |
| 4 | Улирлын ажилгүйдэл | d | Нэг ажлаас нөгөө ажилд шилжих |

4 оноо

36

Өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|-------------------------------|---|--|
| 1 | Өрх гэрийн хэрэглээний зардал | a | ААН-үүдийн хөрөнгө оруулалт болох барилга барих, тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө худалдан авахад гаргасан зардал |
| 2 | Аж ахуйн нэгжийн зардал | ь | Төрөөс төрийн албан хаагчдад зориулан бараа, үйлчилгээ худалдан авах, сургууль, эмнэлэг, зам зэргийг барихад гаргасан зардал |
| 3 | Төрийн зардал | с | Гадаадын иргэдээс бараа, үйлчилгээг худалдан авахад зарцуулсан зардал |
| 4 | Гадаад хэрэглэгчийн зардал | d | Өрх гэрүүд хэрэгпээндээ зориулан хүнс, бараа болон үйлчилгээ худалдан авахад зарцуулсан зардал |
| 5 | Зардал | e | ААН, байгууллага өөрийн үйл ажиллагааг явуулахын тулд эдийн засгийн тодорхой нөөцүүдийг худалдан авахад төлж буй мөнгөн төлбөр юм. |

5 оноо

37

Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|---------------------------------|---|---------|
| 1 | Монгол Улсын Үндсэн хуулийн цэц | a | Хууль |
| 2 | Монгол Улсын Их Хурал | ь | шийдвэр |
| 3 | Монгол Улсын Ерөнхийлөгч | с | Зарлиг |

3 оноо

38

.Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|-------------------------|---|--|
| 1 | Хүний эрх, эрх чөлөө | a | Ардчилсан сонгууль нь бүх нийтийн, нууц, шууд санал хураалт дээр үндэслэнэ. |
| 2 | Тэгш эрх | b | Ардчилсан нийгэмд хаан, ерөнхийлөгч, сайд хэн ч хуулиас дээгүүр эрх эдлэхгүй, иргэн бүр хуулийг сахиж, түүнийг зөрчвөл хариуцлага хүлээнэ. |
| 3 | Олон намын тогтолцоо | c | Нийгмийн харилцаанд оролцох боломжийг илэрхийлсэн ойлголт бөгөөд хүндэтгэн үзэхийг чухалчилдаг. |
| 4 | Хуулийн засаглал | d | Арьс өнгө, шашин шүтлэг, угсаа хүйс, үзэл бодлоор ялгаварлахгүй байхыг хэлнэ |
| 5 | Чөлөөт шударга сонгууль | e | Олон ургалч үзлийг хөгжүүлэх бөгөөд сонгогчдод олон нам, нэр дэвшигчдийн улс төрийн хувилбараас өөрт ашигтай сонгох боломж |

39

.Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|---|---|--|
| 1 | Олон улсын харилцаанд оролцох үүрэг | a | Монгол улс бусад улсын улс төр, эдийн засаг, соёлын хүч чадавхи, үйл ажиллагааг өөрийн боломжоор хянах, үнэлэх явдал юм. |
| 2 | Олон улсын харилцаанд оролцох үйл ажиллагааг чиглэл | b | Олон улсын харилцаанд улс төр, эрх зүй, эдийн засаг, харилцаа, худалдаа, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн гэсэн үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажилладаг. |
| 3 | Олон улсын харилцаанд оролцох нөлөө | c | Олон улсын улс төр, эрх зүй, эдийн засаг, соёлын зэрэг олон талт харилцаанд гадаад бодлогоороо дамжуулан оролцох үйл ажиллагааны цар хүрээ, ач холбогдол |

3 оноо

40

Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|------------------------|---|--|
| 1 | НҮБ | a | Ерөнхий Ассамблей. Аюулгүйн зөвлөл, Эдийн засаг нийгмийн зөвлөл, Олон улсын шүүх |
| 2 | НҮБ-ын зорилго | b | Олон улсын засгийн газар хоорондын хамтын түгээмэл, нээлтгэй, улс орнуурын харилцаа, хамтын ажиллагааны хамгийн олон салбар чиглэлийг хамардаг байгууллага |
| 3 | НҮБ-ын гол байгууллага | c | Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх явхтыг үндсэн зорилго болгодог |

3 оноо

АМЖИЛТ ХҮСБЕ

ШАЛГАЛТЫН ХУГАЦАА: 60 МИНУТ

АНГИ.....СУРАГЧИЙН НЭР.....

ХУВИЛБАР-В

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ

1

Хүмүүс хэрэгцээгээ хангах, зөрчил маргаан, эмх замбараагүй байдалд хүргэхүйн

тулд үүргээ хуваарилан зохион байгуулалтад орж, хянаж, зохицуулах замаар амьдарч буй хамтын амьдралынх нь хэлбэрийг юу гэдэг вэ ?

а. Бүлэг Б. Нийгэм с. Үндэстэн d Гэр бүл е. Нийтлэг

2

Аль нь төрөлх статусын жишээ вэ?

- а. Иргэн С.Болор Халх ястан б.Миний охин сурагч
с.Батбаяр тэргүүлэх зэргийн багш болжээ. d. Миний аав багш
е.Түүхийн багш маань аймгийн 3 удаагийн аварга багш

2 оноо

3

Хүн нийгмийн харилцаанд бие даан оролцох, нийгмийн үйлдлүүдийг хийх чадварыг эзэмших, нийгмээс хүлээж буй шаардлагыг биелүүлэх чадамжтай болох үйл явцыг хэрхэн нэрлэдэг вэ?

- а.Нийгэмшилт Б.Адилсал с.Тээгч
d.Дахин нийгэмшилт е.Анхдагч нийгэмшилт

2 оноо

4

Гажуудлыг арилгах үүднээс нийгмийн гишүүдийн зүгээс гажуудагчийг шийтгэх, засан хүмүүжүүлэх зэрэг хэлбэрээр авч буй арга хэмжээнүүдийн цогцыг юу гэж нэрлэдэг вэ?

- а. Нийгмийн үйлдэл Б. Нийгмийн хяналт с. Нийгмийн гажуудал
d. Гэмт хэрэг е. Харилцан үйлдэл

2 оноо

5

“Хүн бол бэлгэдэл бүтээгч амьтан ” гэж дараах эрдэмтдээс хэн ш тодорхойлсон бэ?

- а. Р.Бенедикт Б. Э.Тайлор с. Ж.Мёрдок d. А.Гидденс е. Э.Кассирер

2 оноо

6

Хүмүүс үзэл санаа, итгэл үнэмшил, ёс суртахууны хувьд харилцан адилгүй сонголт хийдэг. Өөрөөр хэлбэл үнэлэмжийг хувь хүн өөриймшүүлсэн хэр хэмжээ, түвшин юм. Энэ нь:

- а. Үнэлэмж Б. Үнэлэмжийн баримжаа с. Үнэлгээ
d. Үнэт зүйл е. Тохирох хариулт алга

1 оноо

7

Өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|---------------|---|--|
| 1 | Домог | а | Аливаа зүйлийн үнэн эсэхийг шалган тодорхойлох тусгах арга, аргачлал, зарчимд тулгуурладаг. Гол шалгуур нь мэдлэгийг хүлээн зөвшөөрөх явдал мөн. |
| 2 | Шашин | ь | Ямар нэг онолын байгууламж биш, харин мэдрэмж, ид, шид, дүр төсөөлөлд тулгуурласан хүн төрөлхтний язгуур сэтгэлгээ бөгөөд соёлын анхдагч хэв маяг гэж судлаачид үздэг_ |
| 3 | Шинжлэх ухаан | с | Хүмүүсийн сүсэг бишрэлийн хэрэгцээгээр бий болсон оюуны соёлын хэлбэр бөгөөд соён гэгээрүүлэх үүрэгтэйгээс гадна хүнд итгэл бишрэлтэй байхад тусалдаг. |

- а. 1b2c3a Б. 1a2c3b с. 1c2b3a d. 1c2a3b е. 1b 2a 3c

4 оноо

8

Бүхий л соёлд байдаг хэм хэмжээ, дүрэм журам, үнэт зүйлсийг соёл судлалд хэрхэн нэрлэдэг юм байна

- а. Соёлын энтоцентризм хандлага б. Соёлын хажилт с. Соёлын түгээмэл шинж
d. Соёлын өөрчлөлт d. Соёлын хожимдолт

2 оноо

9

Бүх нийтээр хүлээн зөвгөөрсөн Үндсэн хууль ба юм бусад хууль тогтоомж нь хүн бүрт тэгш үйлчлэх явдлыг эрх зүйн шинжлэх ухаанд хэрхэн нэрлэдэг вэ?

- а. Үндсэн хуулийн суурь зарчим б. Эрх зүйд зшираадах ёс
с. Тэгш байдал d. Тэгш эрх e. Үндсэн үүрэг

1 оноо

10

НҮБ хэдэн онд “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” хэиээх баримт бичгийг батлан гаргасан бэ?

- а. 1924 он б. 1940 он с. 1945 он d. 1948 он e. 1992 он

1 оноо

11

Эрх зүйн заримдаг чадамжтай хүн гэж хэнийг хэлэх вэ?

- а. 14-18 хүртэлх насны хүүхэд б. 18- аас дээш насны хүмүүс
с. 72-14 хүртэлх насны хүүхэд d. 7 хүртэлх насны хүүхэд
e. 16 хүртэлх насны хүүхэд

2 оноо

12

Хүний эрхийн төлөө тэмцэгчдийн үзэл баримтлалыг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|-------------------|---|---|
| 1 | Мартин Лютер Кинг | а | Нэг хүүхэд, нэг багш. нэг үзэг. нэг ном дэлхийг өөрчилж чадна. |
| 2 | Элеанор Рузвельт | ь | “Надад мөрөөдөл бий” |
| 3 | Малала Юсуфзай | с | Хүний эрх нь энгийн зүйлээс эхэлдэг. Хүн эрхээ эдлэхийн тулд ямар эрхтэйгээ мэдэх хэрэгтэй. |

- а. 1б2с3а б. 1а2ь3с с. 1с2ь3а d. 1а2с3ь e. 1ь2а3с

4 оноо

13

Хүн амын тодорхой хэсэг болж буй бусдаас дэмжлэг, туслалцаа шаардаж байгаа ахмад настан, эх, хүүхэд, тахир дутуу хүн, нэн ядуу амьдралтай иргэнд тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тэдний амьжиргааг дээшүүлэх, түүнчлэн хүүхэд төрүүлсэн эх, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авсан эх, эцэг болон ихэр хүүхдэд тэтгэмж олгох агуулга бүхий арга хэмжээг..... гэнэ.

- а. Нийгмийн хамгааллын тогтолцоо б. Нийгмийн халамж с. Ажилгүйдлийн тэтгэмж
d. Нийгмийн даатгал e. Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж

2 оноо

14

ДНБ гэж юуг хэлэх вэ?

- а. Үндэсний нийт бүтээгдэхүүнээс үйлдвэрлэлийн явцад элэгдсэн капиталын элэгдлийн шимтгэлийг хасах
б. Тухайн жилд нийт үйлдвэрлэлээс олсон орлогын нийлбэр
с. Дотоод бол гадаад дахь хөрөнгө оруулалттай ААН-үүдийн нэг жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг
d. Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бараа үйлчилгээний зах зээлийн үнийн дүн

- e. Үндэсний цэвэр бүтээгдэхүүнээс худалдаа үйлчилгээний шууд бус татварыг хасаад үлдэх хэсэг

2 оноо

15

Хэрэглэгчдийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын нийлбэр дүнгээр тодорхойлох аргыггэнэ

- а. ДНБ-ийг орлогоор тооцох б. ҮНБ-ийг зардлаар тооцох
с. ДНБ-ийг зардлаар тооцох d. ҮНБ-ийг орлогоор тооцох

1 оноо

е. Нэрлэсэн ДНБ-ийг орлогоор тооцох

16

Утгаар нь зөв тохируулна уу?

- | | |
|-------------------|---------------------------|
| 1. Гипер инфляци | а. Инфляцийн хурд 54.2 % |
| 2. Цогио инфляци | Б. Инфляцийн хурд 123.7 % |
| 3. Мөлхөө инфляци | с. Инфляцийн хурд 4.7 % |
| а. 1Б 2с 3а | Б. 1Б2а3с |
| с. 1а2Б3с | д. 1с2а3Б |
| е. 1с2Б3а | |

3 оноо

17

“Түйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн түвшинд нөлөөлдөг болох”-ыг судлан тогтоосон Америкийн эдийн засагч хэн бэ?

- а. Фишер б. Кейнс с. Хайек д. Смит е. Рикардо

2 оноо

18

Эрчим хүч, үр тариа, бензин, шатахуун зэрэг үйлдвэрлэлийн чухал нөөцүүдийн үнэ огцом өсөх эсвэл цалин хөлс өсөх зэрэг нь инфляцийн аль төрөлд хамаарах вэ?

- а. Эрэлтийн инфляци б. Зардлын инфляци с. Гипер инфляци
д. Мөлхөө инфляци е. Цогио инфляци

19

Иргэд улс төрийн шийдвэр гаргах, хууль боловсруулах үүрэг бүхий албан тушаалтаныг сонгож, түүгээр дамжуулан засаглалыг хэрэгжүүлэх хэлбэр юм. Энд ардчиллын аль хэлбэрийн тухай өгүүлсэн байна вэ?

- А. Сонгодог ардчилал Б. Шууд ардчилал с. Элит ардчилал
д. Төлөөллийн ардчилал е. Олон ургальч ардчилал

2 оноо

20

Монголулс аль онд Үндсэн хуулиа баталж байгаагүй вэ?

- а. 1789.07.14 б. 1940.06.30 с. 1960.07.06 д. 1924.11.26 е. 1992.01.13

2 оноо

21

1990 оны дараах Монгол төрийн үйл ажиллагаанд аль нь үлхамаарах вэ?

- а. Хуульд захирагдан амьдрах ба шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй
б. Хувийн өмчтэй байхыг зөвшөөрч, түүнийхээ үр шимээр амьдрах
с. Сонгох, сонгогдох ардчилсан эрхээ бодитоор эдлэж хэрэгжүүлэх
д. Социалист орнуудын пролетарийн интернационализмд үнэнч байх
Е. Хүний эрхийн түгээмэл зарчмуудыг амьдрал, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх

2 оноо

22

Эрх мэдлийн хуваарилалтын үзэл санааг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|-------------------------|---|----------------|
| 1 | Хууль тогтоох эрх мэдэл | а | Хаан, сайд нар |
| 2 | Гүйцэтгэх эрх мэдэл | б | Парламент |
| 3 | Шүүх эрх мэдэл | с | Шүүх-арми |

- а. 1а2Б3с б. 1Б2с3а с. 1с2а3Б д. 1с2Б3а е. 1а2с3Б

3 оноо

23

1992 оны Монгол улсын Үндсэн хуульд зааснаар иргэний үндсэн үүрэгт хамааралгүй нь аль вэ?

- a. Байгаль орчноо хамгаалах
- b. Албан татвар төлөх
- c. Эх орноо хамгаалах, цэргийн алба хаах
- d. Хуулийг дээдлэн хүндэтгэх, сахин биелүүлэх
- e. Хүний нэр төр, алдар хүнд, ашиг сонирхлыг хүндэтгэх

1 оноо

24

1990 оны өмнөх Монгол төрийн бодлогын гол чиглэлд аль нь хамаарахгүй вэ?

- a. Би давуу эрхтэй гэх байдал
- Б. Ардчилсан бус байдал
- с. Тоталитар дэглэм
- d. Ганц намын тогтолцоо
- e. Дээрх бүгд хамаарна

2 оноо

25

Олон улсын засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр үүсгэн байгуулагдаагүй ашгийн бус хоёроос дээш улсаас хандив авч, үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг хэрхэн нэрлэдэг вэ?

- a. Үндэстэн дамнасан корпораци
- Б. Аж ахуйн нэгж
- с. Олон улсын төрийн бус байгууллага
- d. Сайн дурын байгууллага
- e. Компани

2 оноо

26

Олон улсын харилцаанд хууль ёсны гэх ба тухайн улсыг бүрэн зөвшөөрснийггэж нэрлэдэг.

- a. Статус кво
- Б. Де-факто
- с. Автономит
- d. Де-юре
- e. Транзит

2 оноо

27

“Мөнхийн дайсан гэж байхгүй, мөнхийн хөрш байдаг” гэж хэн хэлсэн бэ?

- a. А.Линколин
- Б. М.Вебер
- с. К.Маркс
- d. У.Черчилль
- e. Ш.Монтескье

2 оноо

28

“Үндэсний язгуур эрх ашиг сонирхлыг сахин хачгаалсан, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйлчилсэн бодлого байна.” Энэ нь Монгол улсын гадаад бодлогын аль зарчим бэ?

- a. Тэнцвэртэй байх
- Б. Идэвхтэй байх
- с. Үндэсний эрх ашигт нийцсэн байх
- d. Олон тулгуурт байх
- e. Шат дараалсан байх

2 оноо

29

Монгол Улсын хоёр хөрштэйгээ харилцах зарчимд аль нь хамаарахгүй вэ?

- a. Эдийн засгийн болон улс төрийн зарчим
- b. Тэнцвэртэй найрсаг байх зарчим
- с. Сайн хөрш, хамтын ажиллагааны зарчим
- d. Олон тулгуурт, стратегийн түншлэлийн зарчим

Дээрх бүгд хамаарна

2 оноо

30

Монгол улс хэдэн он хүртэл олон улсын эрх зүйн хүрээнд де факто статустай байсан бэ?

- a. 1990
- Б. 1924
- с. 1961
- d. 1981
- e. 1979

2 оноо

ХОЁРДУГААР ХЭСЭГ

31

Өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|-------------------|---|--|
| 1 | М.Калмижн | a | Нийгэмшилтэд албан ёсоор үүрэг хүлээгч агент |
| 2 | Гэр бүл | ь | Насанд хүрэгчдийн нийгэмшилт явагдах гол талбар |
| 3 | Нийгмийн судалгаа | с | Судлаачид нийгмийн ертөнцийн тухай асуултад хариулт хайж буй үйл явц |
| 4 | Ажлын байр | d | Нийгэмшүүлэгч үндсэн агент |
| 5 | Сургууль | e | Боловсрол нь хувь хүнийг нийгэмшүүлэх үүргийг гүйцэтгэдэг |

5 оноо

32

Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Соёлын бэлгэдлийн чиг үүрэг | A | Үйлдвэрлэл, шинжлэх ухааны гэх мэт бүтээл туурвих үйл ажиллагаа |
| 2 | Соёлын үнэлэмж, хэм хэмжээний чиг үүрэг | B | Газар ус, өвөг дээдэс, ёс заншлаа дээдэлж ирсэн арга ухаан |
| 3 | Соёлын нэгтгэн зохицуулах чиг үүрэг | C | Сургуулийн хонх бол хичээл эхэлсэн, дууссаныг илтгэх тэмдэг |
| 4 | Соёлын үйл ажиллагааны чиг үүрэг | D | Хүмүүс юуг сайн гэх, юуг зохисгүй гэж үзэхийг ялгах байдал |

4 оноо

33

Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|------------------------------|---|--|
| 1 | Тэгш байдлыг хангах | a | Хүний эрх нь амьдралын бүхий л хүрээг хамрах бөгөөд өөрөөр хэлбэл нэг эрх нь зөрчигдөхөд бусад эрхүүдэд нөлөөлнө. |
| 2 | Ялгаварлан гадуурхахгүй байх | ь | Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрхүүд нэгдмэл, хуваагдашгүй байдаг. |
| 3 | Хүн үнэ цэн, нэр төртэй байх | с | Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнтэй байж, адил хүндэтгэлийг эдэлнэ. |
| 4 | Хуваагдашгүй байх | d | Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, нийгмийн гарал, өмч хөрөнгө төрсөн байдал зэргээс үл хамааран хэнийг ч ялгаварлаж болохгүй |
| 5 | Харилцан хамааралтай | e | Бүх хүмүүс хүн болж төрснийхөө хувьд ижил үнэлэгдэж, адил хүндлэл хүлээнэ гэдгийг баталгаажуулдаг. |

5 оноо

34

| | | |
|------|--|--|
| байх | | |
|------|--|--|

2.4 Өгөгдлийг зөв харгалзуулна уу?/Зоноо/

| | | | |
|---|--------------------------------|---|---|
| 1 | Хүсэлт | а | Иргэн, хуулийн этгээдийн гомдлоор дээд шатны захиргааны байгууллага гомдлыг хянан хэлэлцэх үе шат |
| 2 | Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа | ь | Өөрт болон бусад тулгарч буй асууцлыг шийдвэрлүүлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримт |
| 3 | Захиргааны шийтгэл | с | Захиргааны зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээ |

3 оноо

35

Өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|---------------------------------------|---|---|
| 1 | Бүтцийн ажилгүйдэл | А | Улс төрийн нэг нам ялснаар нөгөө намын төрийн албан хаагчид олноор ажлаас халагдсан |
| 2 | Шилжилтийн ажилгүйдэл | В | Доржийн цалингийн хэмжээ амьдралд хүрэлцэхгүй байгаа тул өөр өндөр цалинтай ажил хайхаар ажлаас гарсан |
| 3 | Ажилгүйдлийн эдийн засгийн үр дагавар | С | Хүн амын орлого, амьжиргааны түвшин буурч ядуурал нэмэгдэн, архидалт, гэмт хэрэг өснө. Боловсролын түвшин доройтон өвчлөл нэмэгдэнэ |
| 4 | Ажилгүйдлийн нийгмийн үр дагавар | Д | Баялаг нэмж үйлдвэрлэх боломжоо алдаж, боломжит үйлдвэрлэлийн хэмжээ буурна. Хөдөлсөрийн нөөц бүрэн ашиглагдахгүйд хүрнэ. |

4 оноо

36

Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|------------------|---|--------------------------------|
| 1 | Цалин | а | Газрын эздийн орлого |
| 2 | Зээлийн хүү | ь | Мөнгө зээлдүүлэгчдийн орлого |
| 3 | Түрээсийн төлбөр | с | Аж ахуйн нэгжийн эздийн орлого |
| 4 | Ашиг | d | Ажиллагчдын орлого |

3 оноо

37

Зөв харгалзуулаарай.

| | | |
|-------------------------------|---|----------|
| Монгол Улсын Ерөнхий сайд | а | Тогтоол |
| Монгол Улсын Засгийн газар | б | Захирамж |
| Аймаг, Нийслэлийн Засаг дарга | с | Тушаал |

3 оноо

38

Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|----------------------------------|---|---|
| 1 | Иргэдийн улс төрийн оролцоо | а | Ардчилсан нийгэм нь иргэдийг боловсролтой болоход анхаардаг бөгөөд боловсролтой иргэд нь ардчиллыг хөгжүүлэх гол хөшүүрэг |
| 2 | Нийгэд тайлагнах, ил тод байх ёс | ь | Ардчилсан нийгэм нь иргэдийн эрхийг хамгаалах, албан тушаалтан хаагчдын эрх мэдлээ урвуулан, хэтрүүлэх явдлаас сэргийлэх |

| | | | |
|---|-------------------------------------|---|--|
| 3 | Эрх мэдлээ хэтрүүлэхэд хяналт тавих | c | Ардчилсан нийгэмд сонгогдсон болон томилогдсон албан тушаалтан ард олонд тайлангаа тавих үүрэггэй.Тэд өөрсдийн үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээнэ. |
| 4 | Тэгш эрх | d | Арьс өнгө, шашин шүтлэг, угсаа, хүйс, үзэл бодлоор ялгаварлахгүй байхыг хэлнэ. |
| 5 | Боловсрол | e | Сонгуульд саналаа өгөх, нэрээ биелүүлэх, жагсаал цуглаан хийх, төрийн байгууллага, албан тушаалтанд санал хүсэлт гаргах зэрэг олон хэлбэрээр хэрэгжинэ. |

39

Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|----------|---|--|
| 1 | Их гүрэн | a | Олон улсын харилцаанд нөлөө багатай ч өөрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэрэгсэлтэй байдаг |
| 2 | Дунд улс | ь | Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бүс нутагтаа баттай нөлөөлдөг, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд байдаг |
| 3 | Бага улс | c | Өөрийн аюулгүй байдлыг төдийгүй хөрш, холбоотой улсууд, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах хүчин чадалтай байдаг |

3 оноо

40

Өгөгдлийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|--------------------------------------|---|--|
| 1 | Монгол улсын гадаад бодлогын зорилго | a | Тухайн улс үндэстэнтэй, шууд хил залган оршдог, тэр улсын дотоод гадаад бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход нөлөө үзүүлдэг улс орнууд |
| 2 | Үндэстэн дамнасан корпораци | ь | Үйл ажиллагаа нь олон улсын шинж чанартай гадаадын хөрөнгө оруулалттай компани |
| 3 | Хөрш орон | c | Дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах |

3 оноо